

**“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

**Компанийн жилийн үйл ажиллагааны
болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан
дүгнэлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 76.1.11 дэх заалт, “Хөвсгөл алтан дуулга” хувьцаат компанийн дүрмийн 7.8.3 дахь заалтыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:


1. “Хөвсгөл алтан дуулга” хувьцаат компанийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг хавсралтаар баталсугай.

2. Тус компанийн 2020 оны үйл ажиллагааг “хангалттай сайн” гэж дүгнэхийн зэрэгцээ Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтэд гарсан санал, өгөгдсөн үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Компанийн удирдлагуудад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.БАТХУЯГ



Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын
 2021 оны 04 дүгээр сарын 16-ны
 өдрийн 01 тоот тогтоолын хавсралт
 ЛЭРЭЭНИЙ

**“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК-ИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
 БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ТУЗ-ИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТ**

Компанийн тухай хууль, Компанийн дүрэмд заасны дагуу Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэлт гарган улмаар Хувьцаа эзэмшигчдийн хурлаар танилцуулж байна.

2020 оны хувьд “Ковид-19” цар тахлын улмаас улс, орон нутгийн хэмжээнд удаа, дараа хөл хорио, хязгаарлалт тогтоон, урьд өмнө тохиолдож байгаагүй эрсдэл, сорилтууд тулгарч, тухайн цагийн үеийн нөхцөл байдалд зохицож үйл ажиллагаагаа явуулах амаргүй үе байлаа.

Улс орны хэмжээнд эдийн засаг, санхүүгийн бэрхшээл тулгарснаас шаардлагатай зээл, урт хугацаат хөрөнгө оруулалт, санхүүжилт бүрэн шийдэгдээгүй, эргэлтийн хөрөнгө оруулалтын дутагдалтай байсан, үйл ажиллагааны гэнэтийн зардал өссөн хэдий ч өөрсдийн дотоод нөөц, хүч боломжийн хирээр тавьсан зорилгоо амжилттай хэрэгжүүлж ажиллажээ.

Компанийн 2020 оны газар тариалангийн үйл ажиллагаанд тавьсан зорилго нь тариалалтыг технологийн дагуу чанартай хийж, ногоон тэжээл болон ашигт таримлуудын тариалалтыг нэмэгдүүлэх, хөрсний үржил шимийг дээшлүүлэн, ээлжлэн тариалах системд шилжих бэлтгэлийг хангах, хөрсний судалгаа хийж хөрс сайжруулах хөтөлбөрийг боловсруулж батлуулан үйл ажиллагааг эхлүүлэх зэрэг байв.

Улаанбуудайн тариалалтад зориулж 135 тн элит үр худалдан авч хэрэглэжээ. Уринш хийх талбайн ургамлын бүтцийг судлуулан хөрсөнд ашигтай ургамлын хувь тооцон байгалийн өөрийн ургамлыг хөрсөнд цант боловсруулагчаар боловсруулалт хийсэн байна. Ургацын чанарыг харгалзан ногоон бордуурт уриншийн тодорхой хэсгийг эзэнт уринш болгон үрийн хураалт хийсэн байна. Ногоон тэжээл тарьсан талбайн ургамлын явцаас шалтгаалан 80 га талбайн ургацыг хурааж ургамлын үлдэгдлийг хөрсөнд хийн уриншинд шилжүүлжээ.

Хөрс хамгаалах чиглэлээр зөвлөх авч ажиллуулан 0,1 га талбайд бордооны олон хувилбар үүнд цаг уурын нөлөө, хөрсний бүтэц, мөн ургаж буй бүтээгдхүүний шимт тэжээлийг судлахаар буудайн туршилт тавин, компост бордоо гарган авч, талбайн бордолтыг 146 га талбайд уриншинд хэрэглэж, хөрсний үржил шимийн судалгаа хийсэн байна.

2020 онд 3444 га-д тариалалт хийх төлөвлөгөөтэй байв. Малын тэжээлийн эрэлт хэрэгцээ нэмэгдэж байгааг харгалзан тэжээлийн ургамлын тариалалтыг төлөвлөсөн хэмжээнээс 117 га-гаар нэмэгдүүлжээ. Нийт үр тарианы ургац 4185,4 тн, ногоон тэжээл боодлоор 360 тн бэлтгэсэн байна. Улаанбуудай 3147 га-д тариалснаас 2990 га талбайд хураалт хийж нийтдээ 3922,3 тн, халтар арвай 27 га-д тариалж 32,7 тн, хошуу будаа 21 га-д тариалж 23,0 тн, тосны ургамал 343 га-д тариалж 97,5 тн, ногоон тэжээл 277 га-д тариалж үр тарианаар 137,1 тн, ногоон тэжээлээр 360 тн-ыг хураан авсан байна.

Нийт 3527 га талбайд уринш боловсруулалт хийсэн ба химийн уриншийн хэмжээг 80 хувиас 30 хувь болгон бууруулжээ. Мөн 827 га талбайг ХАА-н албан журмын даатгалд хамруулан, 76 га талбайг шинээр хашаажуулжээ.

Гурилын үйлдвэрийн хэвийн, найдвартай ажиллагааг хангаж, шаардлагатай засвар үйлчилгээг хийх зорилтын хүрээнд үйлдвэрийн бул ирлэгчийг суурилуулан 20 ш бул ирлэж, 40 ш бул сольж тавьсан байна. Лабораторийг стандартын дагуу тоноглож итгэмжлүүлэх зорилт тавьсан ч итгэмжлүүлэх ажил Ковид-19 болон хүний нөөцийн дутагдлаас шалтгаалан хойшлогдсон байна. Лабораторид шаардлагатай тоног төхөөрөмжийг захиалан суурилуулах ажлыг эхэлсэн байна.

400 квт трансформаторыг шинэчлэн битүүмжлэгдсэн ДП болон өөрчлөн ашиглалтанд оруулж, Мөрөн суманд бүтээгдэхүүн хадгалах агуулахын байртай болжээ.

2020 оны өөрийн хураасан намрын ургацаас 1336 тн, бусад ААН-ээс 2464 тн, ОХУ-аас 6000 тн улаанбуудай тус тус авч нөөцөө бүрдүүлэхээр ажиллаж байна.

Гурилын үйлдвэр өнгөрсөн онд нийт 6.4 мян тн буудай тээрэмдэж, 5.1 мян. тн гурил, 1.1 мянган тн тэжээлийн хивэг, 70 тн бүхэл үрийн гурил үйлдвэрлэн зах зээлд нийлүүлсэн байна.

Компани 2020 онд нийт 7.1 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, 5.5 тэрбум төгрөгийн өртөг гаргаж, 1.1 тэрбум төгрөгийн нийт ашигтай, 1.2 тэрбум төгрөгийн борлуулалт маркетинг, ерөнхий удирдлагын зардал, 0.1 тэрбум төгрөгийн хүүгийн зардалтай, 1.0 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай

ажиллажээ.

2020 онд "Хөвсгөл алтан дуулга" ХК-ийн хувьцаа ТОП-20 индексийг бүрдүүлэгч хувьцаагаар дахин сонгогдож Хөрөнгийн биржийн 2-р ангилалаас 1-р ангилалд орсон байна.

Бодит үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагааг хангах нөөц, ажиллах хүчний нөөц, хэрэглэгч, харилцагчдын хүлээлтийн мөчлөгийг алдахгүй байх нь 2020 онд чухал байсан бөгөөд га-гийн ургацын хэмжээ, нэгж бүтээгдхүүний өртөг зэрэг үзүүлэлтүүд борлуулалтын үнэнд таатай байхуйцаар хуримтлагдсан байна.

Үндсэн тариалалтаас гадна "ашигтай шинэ нэр төрөл туршин тариалж" байгальд ээлтэй, хэрэглэгчид эрэлттэй шинэ баяжмал бүтээгдхүүн нийлүүлэх бэлтгэл, судалгаатай, мэдээллийн суурь баазтай болох ажлын эхлэлээ өргөжүүлэн хөгжүүлэх нь ирээдүйд орлогын нэг чухал эх үүсвэр болох боломжтой гэдгийг ТУЗ-өөс цохон тэмдэглэе.

2020 онд газар тариалан болон боловсруулах үйлдвэрлэлд хийсэн техник технологийн, чанарын удирдлагын багц ажлуудынхаа өгөөжийг сайжруулж, үйл ажиллагаандаа тогтвортой хөгжлийн дараахь 3 чиглэлийг тодорхойлон ажиллаж, компанийн үнэ цэнийг өсгөх шаардлагатай гэж үзэж байна Үүнд:

- Байгаль орчиндоо ээлтэй байх;
- Ажилтнууд болоод хэрэглэгч олон нийт буюу нийгэмд үйл ажиллагаараа эерэг нөлөөтэй, стандартуудыг баримталж, хариуцлагатай ажилладаг байх;
- Байгууллагын засаглалын тогтолцоог шинэ түвшинд баяжуулан хөгжүүлэх, чадварлаг багийг өөрсдөөсөө бүтээх гэсэн асуудал орно.

Өмнөх онд үе шаттай эхлүүлсэн зорилтууд болох "Удирдлагын мэдээллийн тогтолцоо, мэдээллийн урсгал тайлагнал, автоматжуулалтыг нутагшуулах"-тай холбоотой ажлыг үргэлжлүүлэн хийх шаардлагатай байна. Энэ хүрээнд борлуулалт, нягтлан бодох

бүртгэлийн анхан шатны тайлагнал зэрэг үйл ажиллагааны боломжит талбарыг “дигитал бизнесийн загвар”-т хөрвүүлэх талаар дотоод нөөц боломжоо судлан ажиллахыг зөвлөж байна.

2020 онд компанийн бүхий л хүрээний нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг боломжит нөөцөөрөө “хангалттай сайн” удирдан зохион байгуулж ажилласан байна гэж ТУЗ-өөс дүгнэж байна.

Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангуудыг компанийн вэб хуудас болон Монголын хөрөнгийн биржийн вэб хуудсаар холбогдох хуулийн хугацааны дотор олон нийтэд мэдээлсэн тул хувыцаа эзэмшигчид тайлангуудтай танилцах боломжоор хангагдсан гэж үзэж байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

**“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр

№02

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны
зардлын төсвийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62.1.12, 65.6.6 дахь заалтыг үндэслэн “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1.Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.БАТХУЯГ



Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлын 2021 оны 02 тоот тогтоолын

хавсралт

“ Хөвсгөл Алтандуулга “ ХК-ийн ТУЗ-ийн 2021 оны зардлын төсөв

д/д	Зардлын төсөв	Нийт зардал /төг
1	Цалин, урамшуулал, НДШ	55 446 000
2	Шуудан холбооны зардал	1 000 000
3	Бичиг хэргийн зардал	350 000
4	Томилолтын зардал	1 200 000
5	Шатахуун	3 600 000
6	Зар сурталчилгаа	500 000
7	Хурлын зардал	1 000 000
8	Ажлын албаны болон бусад	500 000
	Дүн	63 596 000

**“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

**ТУЗ-ийн гишүүдийн цалин
урамшууллын тухай**

Компанийн тухай хуулийн 62.1.13 дахь заалт, “Хөвсгөл алтан дуулга” Хувьцаат Компанийн дүрмийн 7.8.7, 7.44-д заасныг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:

1. Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 2021 оны цалин, урамшуулал, нэмэгдэл болон Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурал, хороодын хуралд оролцсон оролцооны нэмэгдлийг Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2018 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай” 04 дүгээр тогтоолын дагуу олгож байхаар тогтсугай.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тогтмол цалин, урамшуулал, нэмэгдлийг жилийн эцэст, оролцооны нэмэгдлийг тухай бүр олгож байхыг ерөнхий нягтлан бодогч Ж.Отгоннямд зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Д.БАТХУЯГ

**“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 04 дүгээр сарын 16

№04

Улаанбаатар хот

**“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийг
тусгаарлах замаар өөрчлөн шинээр охин
компани үүсгэн байгуулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 62 дугаар зүйлийн 62.1.2 дахь хэсэг, 22 дугаар зүйл, Компанийн дүрмийн 7.7.1 дэх хэсгийг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийг дараах нөхцлөөр тусгаарлах замаар өөрчлөн байгуулж, шинээр охин компани үүсгэн байгуулахыг “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд зөвшөөрсүгэй. Үүнд:

а) “.....” оноосон нэртэй Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр үүсгэн байгуулах;

б) “.....” ХХК-ийн эхлэлтийн тайлан баланс, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэг бүр нь 1000 (Нэг мянган) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий, нийт 3 991 000 (Гурван сая есөн зуун ерэн нэгэн мянган) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх, нийт 3 991 000 000 (гурван тэрбум есөн зуун ерэн нэгэн сая) төгрөг байхаар тогтоох;

в) “.....” ХХК-ийн нийт гаргасан энгийн хувьцааг “Хөвсгөл алтан дуулга” ХК нь 100% эзэмших;

г) “.....” ХХК нь дараах үйл ажиллагааг хугацаагүйгээр эрхлэх:

1. Газар тариалан;
2. Гадаад дотоод худалдаа;
3. Жимс жимсгэнэ тариалалт;
4. Хүнсний ногоо тариалалт;
5. Хүлэмжийн аж ахуй;
6. Жимс жимсгэнэ, мод бут сөөг тариалалт;
7. ХАА-н түүхий эдийн худалдаа;
8. Хоёрдогч түүхий эд боловсруулалт;
9. ХАА-н шинжлэх ухаан, судалгаа, техникийн үйлчилгээ

д) “.....” ХХК-ийг Монгол улс, Хөвсгөл аймаг, Тариалан сум, Мандал баг, “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн байранд албан ёсоор байрлан үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрөх

е) “.....” ХХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчилсэн найруулгыг батлах.

2. “.....” ХХК-ийн анхны дүрмийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

3. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулах нөхцөл, журмыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

4. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн балансаас **3 991 000 000** (гурван тэрбум есөн зуун ерэн нэгэн сая) төгрөгийн хөрөнгийг тусгаарлаж, “.....” ХХК-ийн балансанд шилжүүлж хуваах балансыг гаргахыг “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд зөвшөөрсүгэй.

5. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн балансаас хөрөнгө тусгаарласантай холбоотойгоор “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, нийт гаргасан энгийн хувьцааны нэрлэсэн үнэ, тоо хэмжээнд өөрчлөлт орохгүй болохыг дурдсугай.

6. “.....” ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн эрх, үүрэг, хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэхийг “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд олгосугай.

7. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулах, охин компани байгуулахтай холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад холбогдох журмын дагуу мэдэгдэх, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт хандаж холбогдох өөрчлөлтийг бүртгүүлэх, шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллахыг “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.БАТХУЯГ



Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2021 оны
04 тоот тогтоолын 1-р хавсралт

“ _____ ” ХХК –ИЙН
ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Монгол Улсад байгуулагдсан “ _____ ” ХХК (цаашид “Компани” гэх) нь Компанийн хуульд заасны дагуу өөрийн Дүрэм (цаашид “Дүрэм” гэх) -ийг батлав.
- 1.2. Компанийн оноосон нэр:
 - 1) Монголоор: “ _____ ХХК”;
 - 2) Англиар: “ _____ ” гэж нэрлэнэ.
- 1.3. Компанийн оршин байгаа газар, албан ёсны хаяг: Монгол улс,
_____ ;
Утас: _____ ;
- 1.4. Компани нь өөрийн албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.
- 1.5. Компани үйл ажиллагаагаа хугацаагүй эрхлэн явуулна.

Хоёр. Компанийн эрх

- 2.1. Компани нь Компанийн тухай хуулийн дагуу зохион байгуулагдсан, бие даасан тайлан тэнцэлтэй, банкинд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хүлээх хуулийн этгээд байна.
- 2.2. Компани нь хувь нийлүүлэгчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж түүнийг захиран зарцуулах эрх нь энэ дүрмээр хязгаарлагдах хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр ажиллана.
- 2.3. Компани нь хувьцаа эзэмшигчийн хүлээх үүргийг хариуцахгүй. Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ.
- 2.4. Компани нь Монгол Улсын нутаг дэвсгэр болон гадаадад өөрийн салбар, төлөөлөгчийн газраа байгуулж болно.
- 2.5. Компани нь өөрийн “ _____ ” ХХК гэсэн нэрийг бүх үйл ажиллагаандаа ашиглана.
- 2.6. Компани нь дотоод, гадаадын банканд төгрөг болон гадаад валютын данстай байна.

Гурав. Компанийн үйл ажиллагааны чиглэл

- 3.1. Компани нь дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулна. Үүнд:
 - 1) Газар тариалан;
 - 2) Гадаад, дотоод худалдаа;
 - 3) Жимс, жимсгэнэ тариалалт;
 - 4) Хүнсний ногоо тариалалт;
 - 5) Хүлэмжийн аж ахуй;
 - 6) Жимс жимсгэнэ, мод бут сөөг тариалалт;

- 7) ХАА-н түүхий эдийн худалдаа;
- 8) Хоёрдогч түүхий эд боловсруулалт;
- 9) ХАА-н шинжлэх ухаан, судалгаа, техникийн үйлчилгээ

Дөрөв. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө

4.1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь **3 991 000 000** (гурван тэрбум есөн зуун ерэн нэгэн сая) төгрөг байна.

4.2. Компанийн зарласан бөгөөд гаргасан энгийн хувьцааны тоо **3 991 000** (гурван сая есөн зуун ерэн нэгэн) ширхэг энгийн хувьцаа байна. Нэгж энгийн хувьцааны нэрлэсэн үнэ **1000** (нэг мянган) төгрөг байна.

4.3. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт үндэслэн дор дурдсан хэлбэрээр өөрчилж болно:

- 1) нэгж хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх эсхүл бууруулах;
- 2) хувьцаа нэмж гаргах замаар өсгөх;
- 3) өөрийн гаргасан хувьцааг эргүүлэн худалдан авч, хүчингүй болгох замаар бууруулах.

Тав. Хувьцаа эзэмшигч

5.1. Компани нь 1 (нэг) Хувьцаа эзэмшигчтэй бөгөөд Хувьцаа эзэмшигч нь Компанийн гаргасан нийт энгийн хувьцааг 100 хувь эзэмшинэ:

Хувьцаа эзэмшигчийн нэр, регистрийн дугаар	Оршин байгаа хаяг	Эзэмшиж буй хувьцааны төрөл, тоо	Нэгж үнэ	Эзэмшиж буй хувьцааны үнэ	Эзэмшлийн хувь хэмжээ
		Энгийн хувьцаа, ширхэг	төгрөг	төгрөг	хувь
"Хөвсгөл алтандуулга" ХК Регистрийн дугаар 2043565	Монгол Улс, Хөвсгөл аймаг, Тариалан сум, Мандал баг			3 991 000 000	100%

Зургаа. Хувьцаа эзэмшигчийн эрх, үүрэг

6.1. Компанийн энгийн Хувьцаа эзэмшигч нь дараах эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ. Үүнд:

- 1) Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа асуудлаар эзэмшиж байгаа хувьцааны тоотой хувь тэнцүү санал өгөх;
- 2) эзэмшиж буй хувьцааны хувь хэмжээгээр ногдол ашиг авах;
- 3) Компанийн талаарх бүх мэдээллийг авах, санхүүгийн болон бусад баримт бичигтэй танилцах;
- 4) Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх;
- 5) Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйл болон Компанийн Дүрэмд заасны дагуу Компаниас нэмж гаргах хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах;
- 6) Компанийн болон бусад Хувьцаа эзэмшигчийн худалдах хувьцаа, түүнийг худалдан авах эрхийн бичиг болон тэдгээрт хөрвөх үнэт цаасыг гуравдагч этгээдэд санал болгох үнээр

өөрийн эзэмшлийн хувьцааныхаа тоонд хувь тэнцүүлэн энэ хууль болон Компанийн Дүрэмд заасны дагуу тэргүүн ээлжид худалдан авах;

Долоо. Компанийн удирдлага

- 7.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг Компанийн цор ганц хувьцаа эзэмшигч болох “Хөвсгөл алтандуулга” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл хэрэгжүүлнэ.
- 7.2. Компани нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Компанийн эрх барих байгууллага төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-тэй байж болно.
- 7.3. Компанийн өдөр тутмын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг Компанийн гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ.

Найм. Хувьцаа эзэмшигчийн бүрэн эрх

- 8.1. Дараах асуудлыг зөвхөн Хувьцаа эзэмшигч шийдвэрлэнэ. Үүнд:
 - 1) Компанийн Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу Компанийн Дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
 - 2) нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар Компанийг өөрчлөн байгуулах, компанийн хэлбэрийг өөрчлөх;
 - 3) Компанийн салбар, төлөөлөгчийн газрыг байгуулах, тэдгээрийн захирлыг томилох, чөлөөлөх;
 - 4) Хараат болон охин компани байгуулах;
 - 5) Компани үнэт цаас гаргах, өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;
 - 6) Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
 - 7) хувьцааг хуваах буюу нэгтгэх;
 - 8) Гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх, түүний эрх хэмжээг тодорхойлох, цалин, урамшууллыг тогтоох;
 - 9) Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Гүйцэтгэх захирлын гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - 10) Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
 - 11) Компанийн тухай хуульд заасны дагуу Компани өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрөх;
 - 12) Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.4 дэх заалтад заасан тайлан
 - 13) Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах;
 - 14) Компанийн аудиторыг сонгох, гэрээний нөхцөлийг тогтоох;
 - 15) Ногдол ашгийн хэмжээг тогтоож, төлөх журмыг батлах;
 - 16) Компанийн эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тодорхойлох;
 - 17) Гүйцэтгэх захирлын саналаар хэлэлцүүлэхээр оруулсан асуудлыг шийдвэрлэх;
 - 18) Энэ Дүрэм, Компанийн тухай хуульд заасан бусад асуудлууд.

Ес. Гүйцэтгэх удирдлага

- 9.1. Компанийн Гүйцэтгэх захирал нь энэ Дүрэм, Хувьцаа эзэмшигчтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

- 9.2. Гүйцэтгэх удирдлага өөрт олгогдсон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, Компанийг төлөөлөх зэргээр Компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.
- 9.3. Гүйцэтгэх захирлын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэргийг Хувьцаа эзэмшигчтэй байгуулсан гэрээнд заана
- 9.4. Гүйцэтгэх захирал өөрт олгогдсон эрх хэмжээний хүрээнд дор дурдсан үүрэг хүлээж, эрх эдэлнэ. Үүнд:
- 1) энэхүү Дүрэм болон холбогдох хууль тогтоомж, Хувьцаа эзэмшигчийн шийдвэр, тухайн жилийн бизнес төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;
 - 2) Компанийн нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;
 - 3) Компанийн ажилтнуудын орон тоо, үндсэн болон нэмэгдэл цалин, тэтгэмж, хөнгөлөлт, урамшууллын хэмжээг тогтоох;
 - 4) ажилтнуудын ажил үүргийн хуваарийг тогтоох, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлаас чөлөөлөх;
 - 5) Компанийн гэрээ хэлцэл, албан захидал, баримт бичигт гарын үсэг зурах;
 - 6) Компанийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулах;
 - 7) энэхүү Дүрэмд заасан үүргээ биечлэн гүйцэтгэх;
 - 8) Компанид учруулсан хохирлыг төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах, Компанид холбогдох иргэний хэрэгт нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох, эсхүл Компанийг төлөөлөх итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилон оролцуулах;
 - 9) Компаниас хөрөнгө захиран зарцуулах төлбөрийн баримтад гарын үсэг зурах;
 - 10) Компанийн санхүүгийн тайлан тэнцэлд хөндлөнгийн хяналт хийх байгууллагатай гэрээ байгуулах, хяналт хийлгэх, тайланг хэлэлцэж дүгнэлт гаргах;
 - 11) Компанийн Гүйцэтгэх удирдлага Компанийн нягтлан бодох бүртгэл санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцах;
 - 12) гэрээнд заасан бусад эрх, үүрэг.

**Арав. Компанийн эрх бүхий албан тушаалтны
хүлээх хариуцлага**

10.1. Компанийн эрх бүхий албан тушаалтан:

- 1) Гүйцэтгэх захирал;
 - 2) Ерөнхий нягтлан бодогчтой адилтгах санхүү хариуцсан захирал, дарга;
- 10.2. Компанийн үйл ажиллагааны цар хүрээнээс хамааруулан Хувьцаа эзэмшигчдийн хурлаас зохих албан тушаалтнуудыг Компанийн эрх бүхий этгээдээр тооцно.
- 10.3. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь өөрийн санаатай, шууд буруутай үйл ажиллагаа, хайнга хайхрамжгүй байдлаас компанид хохирол учруулсан тохиолдолд өөрийн хөрөнгөөр нөхөн төлөх хариуцлага хүлээнэ.

**Арван нэг. Татвар ногдуулалт, санхүүгийн тайлан,
Нөгдөл ашгийн хуваарилалт**

- 11.1. Компанийн санхүүгийн жил нь бүртгэгдсэн өдрөөс эхэлж 12-р сарын 31-ний өдөр дуусна. Компанийг татан буулгах онд санхүүгийн жил нь 01-р сарын 01-ний өдөр эхэлж татан буулгасан өдөр дуусна. Бусад онд санхүүгийн жил нь 01-р сарын 01-ний өдөр эхэлж 12-р сарын 31-ний өдөр дуусна.
- 11.2. Санхүүгийн ба нягтлан бодох бүртгэлийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн нягтлан бодох бүртгэлийн зарчим, стандартын дагуу хөтөлнө.

- 11.3. Компанийн сонгосон аудитор нь Монгол Улсын болон олон улсын нягтлан бодох стандартын дагуу нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий нягтлан бодогч буюу нягтлан бодох, бүртгэлийн үйл ажиллагаа эрхэлдэг компани байна. Хувьцаа эзэмшигчийн шаардлагаар Компанийн санхүүгийн баримт бичгийг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчлэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний үндсэн дээр аудитын байгууллагыг томилон ажиллуулж болно.
- 11.4. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу ногдуулах аливаа татвар, төлбөрийг зохих ёсоор төлнө.
- 11.5. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу орлогын татварыг улсын төсөвт төлсний дараа Компани өөрийн санхүүгийн байдлаас хамааран Хувьцаа эзэмшигчийн шийдвэрээр тогтоосон хэмжээгээр нөөцийн болон бусад санг байгуулж болно.
- 11.6. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу элэгдлийн сан байгуулж болно.
- 11.7. Компанийн нягтлан бодох бүртгэлийн тайланд хийх жилийн аудитыг хөндлөнгийн аудитор хийх бөгөөд аудитын тайланг Хувьцаа эзэмшигчид болон төрийн эрх бүхий байгууллагад гаргаж өгнө.
- 11.8. Компани нь Компанийн тухай хууль болон Компаниас батлан гаргасан ногдол ашиг хуваарилах бодлогод нийцүүлэн ногдол ашиг хуваарилж болно.

**Арван хоёр. Компанийг өөрчлөн байгуулах,
татаан буулгах, өр төлбөрийг барагдуулах**

- 12.1. Компанийг Хувьцаа эзэмшигчийн шийдвэрээр буюу шүүхийн шийдвэрийн дагуу өөрчлөн байгуулах буюу татаан буулгаж болно.
- 12.2. Компанийг татаан буулгасан тохиолдолд түүний өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогыг Хувьцаа эзэмшигчийн шийдвэрээр хуваарилна.
- 12.3. Компанийг өөрчлөн байгуулах буюу татаан буулгах ажлыг Компанийн тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасны дагуу гүйцэтгэнэ.

Арван гурав. Бусад

- 13.1. Энэхүү Дүрмийг 3 (гурван) хувь үйлдэж, Хувьцаа эзэмшигч нэг хувийг, нэг хувийг бүртгэх байгууллагад, үйлдсэн нэг хувийг Компани өөртөө хадгална.
- 13.2. Энэхүү Дүрэм нь Компани бүртгэх байгууллагад бүртгэгдэж гэрчилгээ авсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 13.3. Энэхүү Дүрэм нь Компанийн үндсэн баримт бичиг байна.
- 13.4. Энэхүү Дүрмээр зохицуулаагүй бусад харилцааг Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

2021 оны __ сарын __-ны өдөр

Хувьцаа эзэмшигч:

/гарын үсэг/ гарын үсгийн тайлал



Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2021 оны
04 тоот тогтоолын 2-р хавсралт

**“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК-НИЙГ
ТУСГААРЛАХ ЗАМААР ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ
НӨХЦӨЛ, ЖУРАМ**

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. “Хөвсгөл алтан дуулга” ХК (цаашид “Компани” гэх)-ийн үйл ажиллагааг зогсоохгүйгээр, газар тариалангийн үйл ажиллагаатай, дагалдах Хөрөнгө, үүрэг, хариуцлагыг тусгаарлан Компанийн 100%-ийн хөрөнгө оруулалттай хуулийн этгээд (цаашид “Охин компани” гэх) байгуулан шилжүүлэхэд энэхүү журмыг мөрдлөг болгоно.
- 1.2. Энэ журмын зорилго нь Компанийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулах ерөнхий дарааллыг тогтоох, тусгаарлах комиссыг томилох, түүний чиг үүргийг тодорхойлох, Компанийн балансыг тусгаарлах, Компанийн хөрөнгийг Охин компанид шилжүүлэх, Охин компани байгуулах түүнд эрх, үүрэг, хариуцлагыг шилжүүлэх арга зам, дарааллыг тодорхойлохтой холбогдох харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Шилжүүлэх хөрөнгө, үүрэг, хариуцлага

- 2.1. Компани нь өөрийн балансд бүртгэлтэй дор дурьдсан эрх, оюуны үнэт зүйл, эд хөрөнгө, түүнийг өмчлөх, эзэмших эрх, тэдгээртэй холбоотой үүрэг, хариуцлага, хууль ёсны ашиг сонирхлыг өөрийн үйл ажиллагааг зогсоохгүйгээр хуульд заасан журмын дагуу тусгаарлаж Охин компанийн балансд шилжүүлнэ. Үүнд:
 - 2.1.1 Хөрөнгийн эрх, үүрэг:
 - 1) Эд хөрөнгө (хавсралт №1);
 - 2) Үйлдвэрлэлийн баримт бичгийн жагсаалт (хавсралт №2)
 - 3) Газар тариалангийн бизнесийн бүтцийн орон тоо (хавсралт №3);
 - 4) Орчны болон цаг уурын, хөрсний суурь судалгаа шинжилгээний бааз, өгөдлийн сан (хавсралт №4);
- 2.2. Компаниа тусгаарлах нийт хөрөнгө нь **3 991 000 000** (гурван тэрбум есөн зуун ерэн нэгэн сая) төгрөг байна.

№	Үзүүлэлтийн нэр	Актив \төг\	Пассив \төг\
1	Эргэлтийн хөрөнгө	246 006 901.55	
2	Биологийн хөрөнгө	272 467 408.17	
3	Эргэлтийн бус хөрөнгө	3 472 525 690.28	
4	Толгой компаниас оруулсан хөрөнгө оруулалт		3 991 000 000.00
	Нийт	3 991 000 000.00	3 991 000 000.00

- 2.3. Эргэлтийн бус хөрөнгийг Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарсан өдрийн байдлаар элэгдэл хорогдлыг тооцон шилжүүлнэ.
- 2.4. Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт нь энгийн хувьцаанд хөрвөж, Охин Компанийн санхүүгийн тайлан балансын эздийн өмчийн хэсэгт, Компанийн тусгаарласан хөрөнгө балансын “хөрөнгө” хэсгээс хасагдаж, “хөрөнгө оруулалт” хэсэгт бүртгэгдэнэ.

- 2.5 Компанийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулсан нь Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, зарласан энгийн хувьцааны тоо ширхэг, энгийн хувьцааны нэрлэсэн үнэд өөрчлөлт оруулахгүй болно.
- 2.6 Охин компани нь Компаниас тусдаа бие даасан тайлан баланс, эд хөрөнгөтэй, өөрийн үйл ажиллагаанаас үүдэн гарах хариуцлагыг өөрийн эд хөрөнгөөрөө хариуцах бие даасан үйл ажиллагаа явуулах хуулийн этгээд байна.
- 2.7 Тусгаарлах үйл ажиллагаа нь Компанийг үйл ажиллагаа явуулахад саад учруулахгүй байх ба Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн байна.
- 2.8 Компани нь Хөрөнгө тусгаарлах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллана

Гурав. Тусгаарлах комисс, түүний чиг үүрэг

- 3.1. Хөрөнгө тусгаарлах үйл ажиллагааг хуульд заасан журмын дагуу зохион байгуулах зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөлөөс томилогдсон Тусгаарлах комисс ажиллана.
- 3.2. Тусгаарлах комисс нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг удирдлага болгоно. Үүнд:
 - 3.2.1 Шударга байх;
 - 3.2.2 Албан үүрэгтээ хариуцлагатай хандах;
 - 3.2.3 Үйл ажиллагаандаа холбогдох хууль, тогтоомжийг дагаж мөрдөх;
 - 3.2.4 Компанийг өөрчлөн байгуулах ажиллагааг хурдан, шуурхай хэрэгжүүлэх.
- 3.3. Тусгаарлах комисс нь дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Үүнд:
 - 3.3.1 Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг үндэслэн Компанийг хуваах балансыг эцэслэн боловсруулж, батлуулах;
 - 3.3.2 Компанийг өөрчлөн байгуулагдаж байгаа тухай мэдэгдлийг Компанийн харилцагч, зээлдүүлэгч, хөрөнгө оруулагч, сонирхогч этгээд нарт хуульд заасан журмын дагуу мэдэгдэх;
 - 3.3.3 Холбогдох Хөрөнгийн шилжүүлэх хүсэлтийг харьяа эрх бүхий байгууллагад гаргаж Охин компанийн нэр дээр шилжүүлж гэрчилгээ, гэрээг байгуулж баталгаажуулах;
 - 3.3.4 Компанийг тусгаарлах болон Охин компанийг бүртгүүлэхтэй холбоотой баримт бичгийг бэлтгэж, эрх бүхий байгууллагад бүртгүүлэх;
 - 3.3.5 Компанийг тусгаарлахтай холбоотойгоор өөрчлөн байгуулагдаж байгаа компанийн ажилтнуудыг шинээр үүсгэн байгуулагдаж байгаа охин компанид шилжүүлэн ажиллуулахтай холбоотой үүсэх хөдөлмөрийн харилцааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах;
 - 3.3.6 Компани өөрчлөн байгуулагдаж дууссаны дараа өөрчлөн байгуулагдсан компани болон Охин компанийн үндсэн хөрөнгөд тооллого явуулж, хүлээлцэх;
 - 3.3.7 Оюуны өмч, барааны тэмдэгт, тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, гэрчилгээ, стандартчилал, тохирлын үнэлгээ зэрэг шинээр үүсгэн байгуулагдах компанийн бизнесийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэхэд шаардлагатай асуудлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах;
 - 3.3.8 Энэ журмын хэрэгжилтийг хангаж ажиллах;
 - 3.3.9 Өөрчлөн байгуулахтай холбоотой бусад шаардлагатай ажиллагааг Компанийн ТУЗ-ийн зааварчилгааны дор гүйцэтгэх.

Дөрөв. Хуваах баланс гаргах, батлах

- 4.1. Хуваах балансыг дараах байдлаар гаргаж, Компанийн ТУЗ-ийн хурлаар батлуулна. Үүнд:

4.1.1. Хуваах балансыг хууль тогтоомжид нийцүүлэн Тусгаарлах комисс эцсийн байдлаар үйлдэх бөгөөд балансаас тусгаарлах нийт хөрөнгийн хэмжээ **3 991 000 000** (гурван тэрбум есөн зуун ерэн нэгэн сая) төгрөг байна.

4.1.2. Хуваах балансад үндэслэн Охин компанид оруулсан хөрөнгийн хэмжээг тодорхойлох ба хувь нийлүүдсэн хөрөнгийн хэмжээг Охин компанийн үүсгэн байгуулагчийн шийдвэрээр батална.

Тав. Компанийн өр, төлбөрийг барагдуулах журам

- 5.1. Компанийн өр төлбөрийг дараах журмын дагуу барагдуулна. Үүнд:
 - 5.1.1. Хуваах балансад заасны дагуу Компани нь өөрийн төлбөл зохих татварын өр төлбөр, гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн өөрийн бүх үүргийг хариуцна;
 - 5.1.2. Охин компанид шилжүүлсэн тоног төхөөрөмж, машин механизмийн зээлийн гэрээний болон барьцааны гэрээний үүрэг, өр төлбөрийг шилжүүлэхгүй бөгөөд Компани дангаар хариуцна.
 - 5.1.3. Замд яваа бараа бүтээгдэхүүний улсын хилээр нэвтрүүлэхтэй холбоотой гаалийн татвар, хураамжийг өөрчлөн байгуулагдаж буй Компани хариуцна

Зургаа. Компани өөрчлөн байгуулагдсаныг мэдэгдэх

- 6.1. Компанийн тухай хуульд заасны дагуу Компани өөрчлөн байгуулагдсан тухай компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол гарснаас хойш ажлын 3 өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад мэдэгдэх ажлыг Тусгаарлах комисс хариуцан зохион байгуулна.
- 6.2. Компанийн тухай хуульд заасны дагуу Компани өөрчлөн байгуулагдсан тухай компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол гарснаас хойш ажлын 15 өдрийн дотор тусгаарлах комисс нь харилцагчдад компани тусгаарлах замаар өөрчлөн байгуулагдсан тухай мэдэгдэнэ.
- 6.3. Тусгаарлах комисс нь компани өөрчлөн байгуулагдсан тухай мэдэгдэнэ.
- 6.4. Компани өөрчлөн байгуулагдсаныг Тусгаарлах комисс эрх бүхий бүртгэлийн байгууллагад бүртгүүлнэ.

Долоо. Охин компани үүсгэн байгуулах

- 7.1. Охин компанийг үүсгэн байгуулах шийдвэр, дүрмийг шийдвэрт томилсон итгэмжлэгдсэн төлөөлөгч эрх бүхий бүртгэлийн байгууллагад холбогдох хууль тогтоомжид заасны дагуу бүртгүүлнэ.
- 7.2. Охин компанийг харьяалагдах татварын хэлтэст татвар төлөгчөөр бүртгүүлнэ.

Найм. Хөрөнгө, эрх үүрэг тусгаарлах процесс

- 8.1. Хөрөнгө тусгаарлахтай холбоотойгоор дараах ажиллагаануудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:
 - 8.1.1. Шилжиж буй эд хөрөнгийг хөрөнгийн жагсаалтыг үндэслэн тусгаарлах шийдвэр гарсан үеийн байдлаар бараа материалын тооллого хийж, хүлээлгэж өгөх бөгөөд энэ тухай хүлээлцсэн акт үйлдэнэ.

- 8.1.2. Барааны тэмдгийн гэрчилгээ, патентийн гэрчилгээ, барааны тэмдгийн мэдүүлгийн эрх эзэмшигч өөрчлүүлэх хүсэлтийг монгол улсын оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт гаргаж шийдвэрлүүлэх;
- 8.1.3. бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ эзэмшигч өөрчлүүлэх хүсэлтийг стандартчилал, хэмжил зүйн газарт хандаж шийдвэрлүүлэх;
- 8.1.4 тээврийн хэрэгслийн гэрчилгээний нэр шилжүүлэх хүсэлтийг авто тээврийн үндэсний төвд хандаж гаргаж шийдвэрлүүлэх;
- 8.1.5. Хөдлөх эд хөрөнгийн өмчлөгчийг улсын бүртгэлийн ерөнхий газрын эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газарт өөрчлүүлэх хүсэлтийг гаргаж шийдвэрлүүлэх;
- 8.2. Тусгаарлах комиссын шийдвэрийг компани болон охин компанийн гүйцэтгэх удирдлага бусад эрх бүхий албан тушаалтан хэрэгжүүлэх, үйл ажиллагаанд нь тус тусын хариуцсан чиг үүргийн хүрээнд дэмжлэг үзүүлж ажиллана.
- 8.3. Компанийг тусгаарлах үйл ажиллагааны тайланг компанийн ТУЗ-д танилцуулах үүргийг тусгаарлах комисс хүлээнэ.

Ес. Хүний нөөцийн зохицуулалт

- 9.1. Энэхүү журмын төсөлд заасан компанийн ажлын байр, албан тушаалтан, ажилтнуудыг шилжүүлэх, ажил олгогчийн хүлээсэн эрх, үүргийг шилжүүлэх асуудлыг тусгаарлах комисс болон компани, охин компанитай хамтран Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журам болон Хөдөлмөрийн гэрээг удирдлага болгон зохион байгуулж ажиллана.
- 9.2. Охин компанийн ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулах ажлыг охин компани, түүний удирдлага хариуцан зохион байгуулна.
- 9.3. Тусгаарлах ажиллагааны үед компанийн ажилтнууд нь компанийн өмч хөрөнгийг аливаа байдлаар ашиглан шамшигдуулахгүй байх үүрэгтэй ба үүнд тусгаарлах комисс хяналт тавина.
- 9.4. Охин компанийн бүтэц орон, тоо, Хөдөлмөрийн дотоод журмыг боловсруулан батлуулах ажлыг ТУЗ-өөс гаргасан шийдвэрийн дагуу охин компанийн удирдлага гүйцэтгэж, тусгаарлах комисс хяналт тавьж ажиллана.

Арав. Хариуцлага

- 10.1. Компанийг өөрчлөн байгуулахтай холбогдуулан холбогдох этгээдүүд хүлээсэн үүргээ биелүүлэх үүрэгтэй.
- 10.2. Энэхүү журамд заасан үүргээ гүйцэтгээгүй, компанийн нууц мэдээллийг задруулсан тохиолдолд ажилтанд компанийн Хөдөлмөрийн дотоод журам болон компанийн холбогдох журмын дагуу хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

Арван нэг. Бусад зүйл

- 11.1. Энэхүү журам нь компанийг өөрчлөн байгуулах ажиллагаа дуусгавар болох хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.

"Хөвсгөл алтан дуулга" ХК-ийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулах нөхцөл, журмын төслийн 1-р хавсралт

ЭД ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Эд хөрөнгийн жагсаалт	Дүн
1	Тавилга, эд хөрөнгө	1 617 835.65
2	Компьютер дагалдах хэрэгсэл	829 140.70
3	Машин тоног төхөөрөмж	2 115 931 364.10
4	Тээврийн хэрэгсэл	156 178 437.88
5	Барилга байгууламж	78 974 775.42
6	Биет бус хөрөнгө	1 118 994 136.53
	Нийт биет болон биет бус хөрөнгө	3 472 525 690.28

"Хөвсгөл алтан дуулга" ХК-ийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулах нөхцөл, журмын төслийн 2-р хавсралт

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

Хөрөнгийн нэр	Үл хөдлөхийн УБ дугаар	Газрын гэрчилгээний дугаар
Техникийн агуулах /засварын цех, гарааж/	Ү-1720000016	000199896
Техник тоног төхөөрөмж үйлчилгээний газар	Э-1720000089	000014766
Тариалангийн талбай	870 га	000014768
Тариалангийн талбай	6175 га	000014767

"Хөвсгөл алтан дуулга" ХК-ийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулах нөхцөл, журмын төслийн 3-р хавсралт

Газар тариалангийн бизнесийн бүтцийн орон тоо 16

*"Хөвсгөл алтан дуулга" ХК-ийг тусгаарлах замаар
оорчлон байгуулах нэхцэл, журмын төслийн 4-р хавсралт*

**ОРЧНЫ БОЛОН ЦАГ УУРЫН, ХӨРСНИЙ СУУРЬ СУДАЛГАА
ШИНЖИЛГЭЭНИЙ БААЗ, ӨГӨДЛИЙН САН**

№	Агуулга	Хамрах хугацаа	Мэдээллийн сангийн хэмжээ
1	Хөрсний судалгаа, шинжилгээ, туршилтын түүх		файл эсхүл х.х гэх мэт
2	Цаг уурын нөлөөллийн өгөгдлийн бааз	талбай № 1-43	нийт 7050 га